



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 1/151

Батширээт сум

Хорио цээр тогтоох тухай


Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын нутаг дэвсгэрт ойн хортон шавж устгалын ажил хийгдэж байгаа тул 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийг дуустал хугацаанд Норовлин багийн нутаг Улиасан даваа, Бархын нурууны ар, Шуудан даваа, Цэрэндоржийн даваа, Тэргүүн-Өндөрийн баруун тал, Хогийн толгойн ар, Майхант уулын ар, Мөөгт толгой, Давааны ар, Норовлин уулын ар, Далын давааны ар, зэрэг газруудад мал бэлчээх, иргэдийг аялж зугаалахыг хориглосугай.

2. Хорио цээр тогтоосонтой холбогдуулан иргэдэд мэдээлэл хүргэж ажиллахыг Онон багийн Засаг дарга (Д.Хонгорзул), Норовлин багийн Засаг дарга (Б.Бадамгарав), Барх багийн Засаг дарга (В.Чулуун) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Б.Болд), (Б.Тулга) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501295